*Төсөл*

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны ... дугаар сарын ...-ны өдөр    Дугаар ...    Улаанбаатар хот

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/ болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай.

3. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг баталсантай холбогдуулан хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган зохион байгуулж, түүний биелэлтийг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

*Төсөл*

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны ... дугаар сарын ...-ны өдөр | Дугаар ... | Улаанбаатар хот

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг хавсралтаар батлсугай.

2. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/ болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай.

3. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг баталсантай холбогдуулан хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган зохион байгуулж, түүний биелэлтийг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны
..... дугаар тогтоолын хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2021 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

| № | Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг | Зорилт, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | 2021 онд хүрэх түвшин, үр дүн | 2021 онд шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /тэрбум төгрөг/ | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | |
| **Зорилт 1. Урт хугацааны тогтвортой өсөлтийн суурийг бэхжүүлэх төсөв, мөнгөний бодлого хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 1.1 | Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 /цаашид "МУТХҮБ-2030" гэх/-ын 2.1.7. Зорилт 1 | Эдийн засгийн өсөлтийг урт хугацааны зорилтот түвшинд хүргэх | Дотоодын нийт бүтээгдэхүүн /цаашид "ДНБ" гэх/-ий бодит өсөлт, хувиар | 7.2 | - | Сангийн яам /цаашид "СЯ" гэх/ |
| 1.2 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.6 Зорилт 1,3 | Мөнгөний бодлогын арга хэрэгслийг ашиглан инфляцыг зорилтот түвшинд байлгах | Инфляцын түвшин, оны эцэст хувиар | 7.0 | - | Монголбанк |
| 1.3 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.6, Зорилт 2 | Банкны бус санхүүгийн байгууллагуудын санхүүгийн зах зээлд гүйцэтгэх үүрэг болон хөрөнгө, даатгалын зах зээлийн эзлэх хувийг нэмэгдүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "СЗХ" гэх/, СЯ, Хөрөнгийн бирж болон бусад |
| 1.4 | Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийн 1.7.2.4 дэх заалт, Зээлийн | Монголбанкны зээлийн мэдээллийн санд банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж зээлийн хоршоог хамруулах | Зээлийн мэдээллийн санд банк бус санхүүгийн байгууллагуудын хамрагдалтын хувь | 100 | 0.02 Бусад эх үүсвэр | Монголбанк, СЗХ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хүү бууруулах стратеги 2018-2023-ын 1.4 дэх заалт, Зорилт 8 | | | | | |
| **ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО** | | | | | | |
| **Зорилт 2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, өндөр бүтээмж бүхий газар тариалан, хөнгөн үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, мал аж ахуйн салбарын эрсдэл даах чадавхыг дээшлүүлнэ.** | | | | | | |
| 2.1 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.3 Зорилт 2 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулж, бодлогын хэрэгжилтийг хангах | Шинээр боловсруулах хууль, журмын тоо | 6 | - | Хүнс,хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /цаашид "ХХААХҮЯ" гэх/ |
| 2.2 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.3-ын Зорилт 2 | "Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Үйлдвэрийн аргаар боловсруулах сүүний хэмжээ, сая.литр | 185.0 | 0.2<br>Улсын төсөв | ХХААХҮЯ |
| | | | Үйлдвэрийн аргаар боловсруулах махны хэмжээ, мянган тонн | 60.0 | | |
| 2.3 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.1, Зорилт 1, Монгол мал үндэсний хөтөлбөрийн 3.4.4 дэх заалт | Монгол малчин хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мал аж ахуйн салбарын эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлэх | Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх талбайн хэмжээ, сая.га | 1.5 | 5.0<br>Улсын төсөв | ХХААХҮЯ |
| | | | Монгол малчин хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар | 20.0 | 1.9<br>Улсын төсөв | |
| | | | Бэлчээр ашиглалтыг сайжруулах шинээр гаргах худгийн тоо | 300 | 7.5<br>Гадаад эх үүсвэр | |
| 2.4 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.1, Зорилт 1, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 2.1.3 дахь заалт /цаашид "ТХХААТББ" гэх/ | Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлж, малын ашиг шимийг нэмэгдүүлэх | Мал, амьтны халдварт өвчний бууралт, хувиар | 30.0 | 25.0<br>Улсын төсөв | ХХААХҮЯ |
| | | | Мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчний тархалтыг зогсоох, хувиар | 30.0 | | |
| | | | Шинээр нэмэгдэх цөм сүргийн хээлтэгч, хээлтүүлэгч бог малын тоо, мянган толгой | 320.0 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Шинээр нэмэгдэх цөм сүргийн хээлтэгч, хээлтүүлэгч бод малын тоо, мянган толгой | 80.0 | | |
| 2.5 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.1, Зорилт 3, "ТХХААТББ"-ын 3.1 дахь заалт | Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариаланг хөгжүүлэх, Атрын IV газар тариалангийн тогтвортой хөгжлийн аян хэрэгжүүлэх | Хүнсний ногооны тариалалт нэмэгдэх хувь | 10.0 | 7.1 Улсын төсөв, 26.0 Гадаад эх үүсвэр | ХХААХҮЯ |
| | | | Хураан авах үр тарианы хэмжээ, мянган тонн | 500.0 | | |
| | | | Усалгаатай талбайн хэмжээ, мянган га | 59.0 | | |
| | | | Жимс, жимсгэнийн ургацын хэмжээ, мянган тонн | 3.0 | | |
| | | | Аяны арга хэмжээний хэрэгжилт, хувиар | 30.0 | | |
| 2.6 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.1, Зорилт 2 | Жижиг, дунд үйлдвэр болон загвар хоршоодыг санхүү, зээлийн бодлогоор дэмжих | Ажлын байрны тооны өсөлт, хувиар | 30.0 | 50.0 Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Бусад эх үүсвэр | ХХААХҮЯ |
| | | | Байгуулах загвар хоршооны тоо | 21 | | |
| **Зорилт 3. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.** | | | | | | |
| 3.1 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.4, Зорилт 1, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын /цаашид "ТЭБСББ" гэх/ 3.2 дахь заалт | Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор геологийн судалгааны ажлыг үргэлжлүүлэх | 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажилд хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар | 45.5 | 24.6 Улсын төсөв | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам /цаашид "УУХҮЯ" гэх/ |
| | | | Улсын геологийн иж бүрдэл зургийг L,M хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлын хүрээнд хэрэгжүүлэх төслийн тоо | 2 | | |
| | | | Агаарын геофизикийн судалгааны ажилд хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар | 5.0 | | |
| | | | Монгол орны геохимийн 1:1000000 -ын масштабын зураг зохиох ажлын явц, хувиар | 60.0 | | |
| | | | Ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах | 8 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | сэдэвчилсэн судалгааны ажлын тоо | | | |
| | | | “Алт-2” хөтөлбөрийн хүрээнд Монгол орны алтны хэтийн төлөвийг тогтоох төслийн тоо | 1 | | |
| 3.2 | “МУТХҮБ-2030”-ын 2.1.4, Зорилт 2, “ТЭБСББ”-ын 3.3.7 дахь заалт | Уул уурхайн салбарын томоохон төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх | Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар | 85.0 | 1,815.0 Хувийн хөрөнгө оруулалт | УУХҮЯ |
| | | | Тавантолгойн ордын ашиглалтыг өргөжүүлэн, хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл технологийн парк байгуулах бэлтгэлийг хангах ажлын явц, хувиар | 50.0 | 605.0 Хувийн хөрөнгө оруулалт 956.0 Бусад эх үүсвэр | |
| 3.3 | “МУТХҮБ-2030”-ын 2.1.3, Зорилт 3, “ТЭБСББ”-ын 3.4, Хүнд үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөрийн 3.6, 3.3.6, 3.3.8, 3.4.3 дахь заалт | Хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжих | Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн гэрээ, хэлэлцээрийг байгуулах ажлын явц, хувиар | 100 | - | УУХҮЯ |
| | | | Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар | 20.0 | 434.7 Гадаад эх үүсвэр | |
| | | | Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий тос дамжуулах дэд бүтцийн бэлтгэл ажлын явц, хувиар | 100 | - | |
| | | | Алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэр байгуулах ажлын явц, хувиар | 100 | 265.0 Хувийн хөрөнгө оруулалт | |
| | | | Говийн бүсэд ган төмөр, коксын үйлдвэрийн цогцолбор байгуулах төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний судалгааг хийх ажлын явц, хувиар | 100 | 0.07 Хувийн хөрөнгө оруулалт | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 4. Эдийн засгийн өсөлтийг хангах хүрээнд ашиглалтад байгаа цахилгаан станцуудыг өргөтгөн, шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлж эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангана.** | | | | | | |
| 4.1 | “МУТХҮБ-2030”-ын 2.1.5, Зорилт 1, Төрөөс эрчим хүчний салбарт баримтлах бодлого /цаашид “ТЭХТББ” гэх/-ын 3.2.1.2 дахь заалт | Эрчим хүчний салбарын тасралтгүй найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудыг өргөтгөн шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх | Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх төслийн барилга угсралтын ажлын явц, хувиар | 90.0 | 110.1 Хөгжлийн банк | Эрчим хүчний яам /цаашид “ЭХЯ” гэх/ |
| | | | Хоёрдугаар дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 300 МВт-аар өргөтгөх төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх ажлын явц, хувиар | 100 | - | |
| | | | Гуравдугаар дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 75 МВт-аар өргөтгөх төслийн барилга угсралтын ажлын явц, хувиар | 10.0 | 101.4 Хөгжлийн банк | |
| | | | Амгалангийн дулааны станцыг 50 МВт-аар өргөтгөх төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх ажлын явц, хувиар | 100 | - | |
| 4.2 | “МУТХҮБ-2030”-ын 2.1.5, Зорилт 1, “ТЭХТББ”-ын 3.2.1.2 дахь заалт | Өмнөд бүсийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах шинэ эх үүсвэр барих | Тавантолгойн 300 МВт-ын цахилгаан станцын барилгын ажлын явц, хувиар | 10.0 | 289.8 Хувийн хөрөнгө оруулалт | ЭХЯ |
| | | | Багануурын 400 МВт-ын дулааны цахилгаан станц барих төслийн барилгын ажлын явц, хувиар | 25.0 | 289.8 Хувийн хөрөнгө оруулалт | |
| 4.3 | “МУТХҮБ-2030”-ын 2.1.5 Зорилт 2, “ТЭХТББ”-ын 3.2.6 дахь заалт | Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлэх | Эгийн голын 315 МВт-ын усан цахилгаан станц барих төслийн биологийн олон янз байдлын судалгаа хийх ажлын явц, хувиар | 100 | 1.5 Хөгжлийн банк | ЭХЯ |
| | | | Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станц барих ажлын явц, хувиар | 20.0 | 86.9 Гадаад эх үүсвэр | |
| | | | Том чадлын 100 МВт-ын цэнэг хураагуурыг барьж эрчим хүчний нэгдсэн системд холбох ажлын явц, хувиар | 100 | 83.0 Гадаад эх үүсвэр | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Баруун бүсэд сэргээгдэх эрчим хүчийг дэлгэрүүлэх төслийн барилгын ажлын явц, хувиар | 75.0 | 76.7<br>Гадаад эх үүсвэр | |
| | | | Усан цэнэгт цахилгаан станц барих төслийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлын явц, хувиар | 100 | - | |
| 4.4 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.5 Зорилт 1, "ТЭХТББ"-ын 3.2.1.5 дахь заалт | Бүс нутгийн эрчим хүчний систем, хүнд үйлдвэрүүд, том хэрэглэгчид, эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам барьж, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг үргэлжлүүлэх | Төвийн бүсийн 220 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг шинээр барих, өргөтгөх ажлын явц, хувиар | 10.0 | 17.3<br>Гадаад эх үүсвэр | ЭХЯ |
| | | | Эрдэнэбүрэн-Улиастайн 220 кВт-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийн судалгааны ажлыг хийх явц, хувиар | 100 | - | |
| | | | Төвийн бүсийн дамжуулах сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн барилгын ажлын явц, хувиар | 20.0 | 11.6<br>Гадаад эх үүсвэр | |
| 4.5 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.5 Зорилт 1, "ТЭХТББ"-ын 3.2.1.4 дахь заалт | Аймгийн төвүүд болон томоохон хот суурин газарт дулааны станц, шугам сүлжээг шинээр барих, өргөтгөх, эрчим хүчээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх | Аймгийн төвүүдийн дулааны станцын барилгын ажлын явц, хувиар | 50.0 | 129.5<br>Гадаад эх үүсвэр | ЭХЯ |
| | | | Улаанбаатар хотын дулааны шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлийн төслийн барилгын ажлын явц, хувиар | 30.0 | 13.0<br>Гадаад эх үүсвэр | |
| | | | Хот, суурин газрын цахилгаан, дулааны шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл хийх ажлын явц, хувиар | 100 | 30.0<br>Улсын төсөв | |
| 4.6 | "ТЭХТББ"-ын 3.2.5.3, Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийн 4.11 дэх заалт | Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, цахилгаан түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үе шаттайгаар хийж, алдагдлыг бууруулах шинэ техник, технологи нэвтрүүлэх | Багануур, Зүүн өмнөд бүс, Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулах төслийг хэрэгжүүлэх ажлын явц, хувиар | 70.0 | 28.9<br>Гадаад эх үүсвэр | ЭХЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх | | | | |
| **Зорилт 5. Эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн суурь дэд бүтэц, зам, тээврийн салбарыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 5.1 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.5, Зорилт 3 | Олон улс, хот хоорондын болон орон нутгийн чанартай авто зам, гүүрний сүлжээг өргөтгөн хөгжүүлэх | Шинээр ашиглалтад орох авто замын урт, км | 240.12 | 64.5 Улсын төсөв, 23.9 Гадаад эх үүсвэр | Зам, тээврийн хөгжлийн яам /цаашид "ЗТХЯ" гэх/ |
| | | | Шинээр ашиглалтад орох гүүрний урт, метр | 718.26 | 14.5 Улсын төсөв | |
| | | | Улсын чанартай авто зам, гүүрний байнгын засвар арчлалтын явц, хувиар | 100 | 52.0 Улсын төсөв | |
| | | | Өргөтгөл, шинэчлэл хийх авто замын урт,км | 335.9 | 24.6 Улсын төсөв, 246.7 Гадаад эх үүсвэр | |
| | | | Өргөтгөл, шинэчлэл хийх гүүрний урт, метр | 127 | 2.0 Улсын төсөв | |
| 5.2 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.5, Зорилт 4, Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлогын /цаашид "ТАТСББ" гэх/ 2.3.3.4 дэх заалт | Зорчигч тээврийн автобуудал барих төслийг хэрэгжүүлж эхлэх | Говь-Алтай, Дорнод, Ховд аймгийн зорчигч тээврийн автобуудал барих ажлын явц, хувиар | 10.0 | 9.0 Төр, хувийн хэвшлийн түншлэл | ЗТХЯ |
| 5.3 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.5, Зорилт 3, "ТАТСББ"-ын 2.3.2.4 дэх заалт | Логистикийн төв, холимог тээврийн терминал барих төслийг хэрэгжүүлж эхлэх | Улаанбаатар, Дархан-Уул, Дорноговь аймгуудад логистикийн төв, холимог тээврийн терминал барих ажлын явц, хувиар | 10.0 | 390.0 Төр, хувийн хэвшлийн түншлэл | ЗТХЯ |
| 5.4 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.5, Зорилт 4 | Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн гэрчилгээг олгох, шалгалт авах үйл ажиллагааг хөнгөвчлөх, нэгдсэн зохион байгуулалтад оруулах | Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн болон мэргэшсэн жолоочийн шалгалтын нэгдсэн төв байгуулах ажлын явц, хувиар | 100 | 20.0 Төр, хувийн хэвшлийн түншлэл | ЗТХЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5.5 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.5, Зорилт 4, "ТАТСББ"-ын 2.3.3.2 дахь заалт | Аюулгүй, найдвартай, их багтаамжийн нийтийн тээврийг хөгжүүлэх | Шинэчлэгдэх автобусны тоо | 200 | 80.0 Гадаад эх үүсвэр | ЗТХЯ |
| 5.6 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.5, Зорилт 4, "ТАТСББ"-ын 2.3.5.2, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний хөтөлбөрийн 3.3.3 дахь заалт | Тээврийн хэрэгслийн техникийн хяналт, татвар, даатгал, авто үйлчилгээний салбарт цахим системийг нэвтрүүлэх | Цахим системийг нэвтрүүлэх ажлын явц, хувиар | 100 | 2.1 Төр, хувийн хэвшлийн түншлэл | ЗТХЯ |
| 5.7 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.5, Зорилт 3, Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын 3.2.4 дэх заалт | Эдийн засгийн өсөлтийг дэмжих төмөр замын бүтээн байгуулалтын төслийг эрчимжүүлэх | Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар | 100 | 1,538.8 Хувийн хөрөнгө оруулалт | ЗТХЯ |
| 5.8 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.5, Зорилт 4 | Орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх | Ховд, Хөвсгөл, Дорнод, Хэнтий аймгийн нисэх буудлыг 4C зэрэглэл бүхий хүчин чадалтай болгох ажлын явц, хувиар | 25.0 | 67.3 Гадаад эх үүсвэр | ЗТХЯ |
| **ГУРАВ. БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО** | | | | | | |
| **Зорилт 6. Иргэдийн эрүүл, аюулгүй орчныг хангасан хот суурин газрын төлөвлөлт, орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | |
| 6.1 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.5, Зорилт 5, Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого /цаашид "ТБСТББ" гэх/-ын 2.3.3 дахь заалт | "Монгол Улсын хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" -ийг боловсруулах | Төсөл боловсруулах ажлын явц, хувиар | 100 | 1.6 Улсын төсөв | Барилга хот байгуулалтын яам /цаашид "БХБЯ" гэх/ |
| 6.2 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.5, Зорилт 5, "ТБСТББ"-ын 2.3.3 дахь заалт | Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах | Орхон аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын явц, хувиар | 100 | 6.7 Бусад эх үүсвэр | БХБЯ |
| | | | Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын явц, хувиар | 100 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Зүүн бүсийн хөгжлийн төсөл боловсруулах ажлын явц, хувиар | 100 | | |
| | | | Аэросити хотын инженерийн бэлтгэл, ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын явц, хувиар | 100 | | |
| 6.3 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.5, Зорилт 5, "ТБСТББ"-ын 2.3.8.1 дэх заалт | Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, шинэчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох | Монгол Улсын нутаг дэвгэрийн 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах ажлын явц, хувиар | 10.0 | 8.7 Бусад эх үүсвэр | БХБЯ |
| | | | Өндрийн II дугаар ангийн сүлжээний хайгуул, судалгаа, хэмжилт хийх шугамын урт, км | 7391.4 | 1.6 Бусад эх үүсвэр | |
| 6.4 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.5, Зорилт 6, "ТБСТББ"-ын 2.3.5 дахь заалт | Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх | Тоног төхөөрөмжөөр хангах ажлын явц, хувиар | 30.0 | 4.8 Гадаад эх үүсвэр | БХБЯ |
| 6.5 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.5, Зорилт 6, 150 мянган айл-Орон сууц үндэсний хөтөлбөрийн 4.4 дэх заалт | Иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, гэр хороололд амины орон сууц барихад урт хугацааны хөнгөлөлттэй нөхцөлөөр ипотекийн зээл олгох, "Түрээсийн орон сууц хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх | Солонго 1, 2 төслийн барилга угсралтын ажлын явц, хувиар | 15.0 | 120.0 Гадаад эх үүсвэр | БХБЯ |
| | | | Ипотекийн зээлд хамрагдах иргэдийн тоо | 6000 | 60.0 Улсын төсөв, 360.0 Бусад эх үүсвэр | |
| | | | Түрээсийн орон сууц хөтөлбөрийг 10 аймагт хэрэгжүүлэх ажлын явц, хувиар | 100 | 60.0 Бусад эх үүсвэр | |
| | | | "Ногоон нуур 1008 айлын орон сууц" төслийг хэрэгжилтийг явц, хувиар | 80.0 | 70.0 Гадаад эх үүвэр | |
| 6.6 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.5, Зорилт 6, "ТБСТББ"-ын 2.3.7 дахь заалт | Гэр хороолол инженерийн хангамжийн "Дэд бүтэц" төвийг байгуулах | "Дэд бүтэц" төвд холбогдсон гэр хорооллын айл өрхийн тоо | 750 | 30.0 Гадаад эх үүсвэр | БХБЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6.7 | “МУТХҮБ-2030”-ын 2.1.5, Зорилт 6, “ТБСТББ”-ын 2.3.7.3 дахь заалт | Улаанбаатар хот болон Зүүн өмнөд говийн бүсэд цэвэрлэх байгууламжийг барих ажлыг үргэлжлүүлэх | Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн барилгын ажлын явц, хувиар | 50.0 | 218.6<br>Гадаад эх үүсвэр | БХБЯ |
| | | | Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоох суурин газрын хөгжлийн төслийн явц, хувиар | 90.0 | 9.5<br>Гадаад эх үүсвэр | |
| 6.8 | “МУТХҮБ-2030”-ын 2.1.5, Зорилт 6, “ТБСТББ”-ын 2.3.7.2, 2.3.7.3 дахь заалт | Нийслэл, аймгуудын инженерийн шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, үерийн байгууламжийг үе шаттай барьж байгуулах | Үерийн байгууламжийг үе шаттай барьж байгуулах ажлын явц, хувиар | 100 | 6.5<br>Улсын төсөв | БХБЯ |
| | | | Инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажлын явц, хувиар | 100 | 30.1<br>Улсын төсөв | |
| 6.9 | “МУТХҮБ-2030”-ын 2.1.5, Зорилт 5 | Бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах | Хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг | 1 | - | Үндэсний хөгжлийн газар |
| **Зорилт 7. Агаар, орчны бохирдлыг бууруулан, байгалийн нөөцийн хамгаалалт, зохистой ашиглалтын бодлогыг хэрэгжүүлж, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.** | | | | | | |
| 7.1 | “МУТХҮБ-2030”-ын 2.3.1, 2.3.3, Зорилт 2, Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 4.1.8-4.1.10, 4.2.2-4.2.4, 4.2.7, 4.3.1-4.3.3 дахь заалт | Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хувиар | 80-иас доошгүй | 75.2<br>Улсын төсөв | Байгаль орчин, аялал жуулчлалын яам /цаашид “БОАЖЯ” гэх, ЭХЯ, БХБЯ, ЗТХЯ, Аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар /цаашид “АНЗДТГ” гэх/ |
| | | | Улаанбаатар хотын агаар дахь PM 2.5 тоосонцрын агууламжийн бууралт, хувиар | 15 | | |
| 7.2 | “МУТХҮБ-2030”-ын 2.3.1, 2.3.3, Зорилт 1, 2 | Хүн амын ундны болон ахуйн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох хайгуул судалгааны ажлыг хийж, бороо, цасны усыг хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах, гол, горхи, булаг, шандын эхийг хашиж хамгаалах | Хот суурин газрын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох хайгуул, судалгааны ажлын тоо | 2 | 0.5<br>Улсын төсөв | БОАЖЯ, АНЗДТГ |
| | | | Гидрогеологийн 1:200 000 масштабын зураглал, хайгуул судалгааны ажилд хамрагдах газар, нутгийн талбайн хэмжээ, мянган га | 35.0 | 1.0<br>Улсын төсөв | |
| | | | Шинээр байгуулах хөв, цөөрмийн тоо | 3-аас доошгүй | 0.6<br>Улсын төсөв | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Хамгаалалт хийх булаг, шандын тоо | 100-аас доошгүй | - | |
| 7.3 | "МУТХҮБ-2030"-ын 2.3.1, Зорилт 1, 2.3.3, Зорилт 1 | Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийг улсын тусгай хамгаалалтад судалгаа хийж авах, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх | Тусгай хамгаалалтад авах судалгаа хийх газар нутгийн хэмжээ, мянган га | 600.0 | 0.2<br>Улсын төсөв | БОАЖЯ |
| | | | Биологийн олон янз байдлын судалгаа, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо | 3-аас доошгүй | 1.5<br>Гадаад эх үүсвэр | |
| 7.4 | "МУТХҮБ-2030"-ын 2.3.3, Зорилт 1, Хөрс хамгаалах газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 2.2.1, 2.2.3, 3.1.3, 3.1.7, 3.1.9 дэх заалт | Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах | Цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо | 5-аас доошгүй | 1.3<br>Улсын төсөв | БОАЖЯ |
| 7.5 | "МУТХҮБ-2030"-ын 2.3.3, Зорилт 1, Төрөөс ойн талаар баримтлах бодлогын 3.1-3.3 дахь заалт | Ойжуулалт, нөхөн сэргээлтийг чанаржуулан, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлж, хүлэмжийн хийг шингээх чадварыг нэмэгдүүлэх | Ойжуулалт, нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ, мянган га | 12.0-аас багагүй | 5.7<br>Улсын төсөв | БОАЖЯ |
| | | | Ойн цэвэрлэгээ хийх талбайн хэмжээ, мянган га | 30.0-аас багагүй | | |
| | | | Ойн хөнөөлт шавжийн хөнөөлийн голомттой тэмцэх талбайн хэмжээ, мянган га | 50.0-аас багагүй | | |
| 7.6 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.2, Зорилт 1, Төрөөс аялал жуулчлалын талаар баримтлах бодлогын 2.3.2, 2.3.4, 4.2.4, 4.2.6, 4.4.4 дэх заалт | Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн хэрэгжилтийг хангах | Хэрэгжилтийн явц, хувиар | 30-аас доошгүй | 29.0<br>Гадаад эх үүсвэр | БОАЖЯ |
| **Зорилт 8. Онцгой байдлын салбарын агаараас аврах ажиллагааг бэхжүүлж, гамшгийн үеийн бэлэн байдлын түвшнийг дээшлүүлнэ.** | | | | | | |
| 8.1 | "МУТХҮБ-2030"-ын 2.3.2, Зорилт 1, Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги- | Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, аврах, гал унтраах ангийн чадавхыг сайжруулах | Шинээр барьж ашиглалтад оруулах гал түймэр унтраах, аврах ангийн барилгын тоо | 1 | 10.2<br>Улсын төсөв | Онцгой байдлын ерөнхий газар /цаашид "ОБЕГ" гэх/ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2030 /цаашид "ТЦБХС-2030" гэх/-ын 4.3.5 дахь заалт | | | | | |
| 8.2 | "МУТХҮБ-2030"-ын 2.3.2, "ТЦБХС-2030"-ын 4.3.5 дахь заалт, Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийн 4.2.2.2, 4.2.3.2 дахь заалт | Онцгой байдлын албаны техник, тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулах төсөл хэрэгжүүлэх | Агаараас аврах ажиллагаа явуулах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх ажлын явц, хувиар | 70.0 | 21.0<br>Гадаад эх үүсвэр | ОБЕГ |
| **ДӨРӨВ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НИЙГМИЙН БОДЛОГО** | | | | | | |
| **Зорилт 9. Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, стандартын шаардлага хангасан сургалтын орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | |
| 9.1 | "МУТХҮБ-2030"-ын 2.2.3, Зорилт 1, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /цаашид "ТБТББ" гэх/-ын 4.3 дахь заалт, Боловсрол үндэсний хөтөлбөрийн 1.1 дэх заалт | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, сургуульд бэлтгэгдсэн байдлын чанарын үнэлгээг үндэсний хэмжээнд зохион байгуулах | Хамран сургалтын бохир жин, хувиар | 87.0 | 66.4<br>Улсын төсөв | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам /цаашид "БСШУСЯ" гэх/ |
| | | | Шинээр ашиглалтад орох цэцэрлэгийн тоо | 53 | | |
| | | | Чанарын үнэлгээний программ хангамжийн тоо | 1 | | |
| 9.2 | "МУТХҮБ-2030"-ын 2.2.3, Зорилт 2, "ТБТББ"-ын 4.3 дахь заалт, Боловсрол үндэсний хөтөлбөрийн 2.1 дэх заалт | Ерөнхий боловсролын сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, тоног төхөөрөмжөөр хангах | Шинээр ашиглалтад орох сургуулийн тоо | 48 | 89.1<br>Улсын төсөв | БСШУСЯ |
| | | | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 100 | | |
| 9.3 | "МУТХҮБ-2030"-ын 2.2.3, Зорилт 1,2, "ТБТББ"-ын 4.3 дахь заалт, Боловсрол үндэсний хөтөлбөрийн 1.1 дэх заалт | Хөдөө, орон нутгийн цэцэрлэг, сургууль, дотуур байрыг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо | 42 | 4.8<br>Улсын төсөв | БСШУСЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 9.4 | “МУТХҮБ-2030”-ын 2.2.3, Зорилт 1,2, “ТБТББ”-ын 3.10 дахь заалт, Боловсрол үндэсний хөтөлбөрийн 1.1 дэх заалт | Ердийн хэв шинжтэй цэцэрлэг, сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах нийгэм, сэтгэлзүй, боловсрол, сургалтын таатай орчныг бүрдүүлэх | Орчин нөхцөлийг бүрдүүлэх цэцэрлэг, сургуулийн тоо | 60 | 0.4<br>Улсын төсөв | БСШУСЯ |
| 9.5 | “МУТХҮБ-2030”-ын 2.2.3, Зорилт 3, “ТБТББ”-ын 3.14 дахь заалт, Боловсрол үндэсний хөтөлбөрийн 5.4 дэх заалт | Насан туршдаа суралцахуйг дэмжих үндэсний тогтолцоог бүрдүүлэх, нээлттэй боловсролын цахим сургалтын агуулга боловсруулж, түгээх эрх зүйн орчныг бий болгох | Батлагдсан бодлогын баримт бичгийн тоо | 2 | - | БСШУСЯ |
| **Зорилт 10. Соёл, урлаг, спортын салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, бүтээн байгуулалтын ажлыг үе шаттай зохион байгуулна.** | | | | | | |
| 10.1 | Сонгодог урлаг үндэсний хөтөлбөрийн 3.1.3 дахь заалт, Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн 3.3.4 дэх заалт, Чулуун соёлын өв үндэсний хөтөлбөрийн 2.2.2 дахь заалт | Иргэдийн соёлын хэрэгцээ, шаардлага, үйлчилгээний чанар, үр дүнтэй уялдуулан соёл урлагийн салбарын бүтээн байгуулалтыг үе шаттай зохион байгуулах | Шинээр ашиглалтад орох соёлын төв, музей, театрын тоо | 29 | 190.7<br>Улсын төсөв | БСШУСЯ |
| 10.2 | Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн 3.3.4 дэх заалт | Иргэдийн оюуны соёл, боловсролыг дэмжих хүрээнд нийтийн номын сангийн хүртээмжийг нэмэгдүүлэх | Шинээр ашиглалтад орох номын сангийн тоо | 2 | 50.7<br>Улсын төсөв | БСШУСЯ |
| 10.3 | Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлогын 2.2.1 дэх заалт, Биеийн тамир, спортын хөгжүүлэх үндэсний | Спортын салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих бодлого хэрэгжүүлэх | Шинээр ашиглалтад орох спорт цогцолбор, ордон, заал, цэнгэлдэх хүрээлэнгийн тоо | 18 | 94.0<br>Улсын төсөв | БСШУСЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөрийн 2.2.1 дэх заалт | | | | | |
| **Зорилт 11. Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, шинжлэх ухааны салбарын дэд бүтцийг хөгжүүлнэ.** | | | | | | |
| 11.1 | "МУТХҮБ-2030"-ын 2.2.3, Зорилт 5, Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого /цаашид "ТШУТТББ" гэх/-ын 4.1.9, 4.6 дахь заалт, Шинжлэх ухаан, технологи, инновацын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийн 2.2.2 дахь заалт | Эрдэм шинжилгээний байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, салбарын олон талт хамтын ажиллагааг өргөжүүлж судалгаа боловсруулалтын ажлыг сайжруулах | Шинжлэх ухаан, технологийн төслийн тоо | 550-аас доошгүй | 52.0 Шинжлэх ухаан, технологийн сан | БСШУСЯ |
| 11.2 | "МУТХҮБ-2030"-ын 2.2.3, Зорилт 5, "ТШУТТББ"-ын 2.2.5, 2.3.4 дэх заалт, Төрөөс инновацын талаар баримтлах бодлогын 2.2.2 дахь заалт, Үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрийн 2.2.1, 2.2.2 дахь заалт | Инновацын тэргүүлэх чиглэлийн хүрээнд хөрөнгө нөөцийг төвлөрүүлж, шинжлэх ухаан, инновацын дэд бүтцийг сайжруулах | Шинжлэх ухаан, инновацын төвийн барилгын ажлын явц, хувиар | 30.0 | 45.5 Улсын төсөв | БСШУСЯ |
| **Зорилт 12. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, шуурхай байдлыг хангана.** | | | | | | |
| 12.1 | Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого- /цаашид "ТМХХХТББ" гэх/-ын 2.3.8, 3.9.5 дахь заалт | Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд зарим сумдад төрийн цахим үйлчилгээний Хур системийг нэвтрүүлэх | Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх төвийн тоо | 30 | 2.0 Улсын төсөв | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар /цаашид "ХХМТГ" гэх/ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 12.2 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.5, Зорилт 7, "ТМХХХТББ"-ын 2.3.2, 3.3.4 дахь заалт | Алслагдсан сумдыг өргөн зурвасын шилэн кабелийн сүлжээнд холбох | Шилэн кабелийн сүлжээнд холбогдох сумын тоо | 6 | 0.7<br>Улсын төсөв | ХХМТГ |
| 12.3 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн 3.6.1.1 дэх заалт | Монгол Улсын хөгжлийн дунд, урт хугацааны бодлогын зорилт, түүний хэрэгжилтийг хэмжихэд шаардлагатай нийгэм эдийн засгийг хамарсан өргөн хүрээний тооллого, тооцоо судалгаа хийх, түүний бэлтгэл ажил хангахтай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 7.6<br>Улсын төсөв | Үндэсний Статистикийн хороо |
| **Зорилт 13. Иргэний эрүүл мэндийн бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.** | | | | | | |
| 13.1 | "МУТХҮБ-2030"-ын 2.2.2, Зорилт 1, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого /цаашид "ТЭМТББ" гэх/-ын 2.4.2.10, 2.4.2.12 дахь заалт, Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр /цаашид "ХБӨТҮХ" гэх/-ийн 3.2.1 дэх заалт. | Иргэний эрүүл мэндийн бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгийг нэмэгдүүлэх | Хүн амын дунд эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтын хувь | 30.0 | 23.9<br>Эрүүл мэндийн даатгалын сан<br><br>22.1<br>Гадаад эх үүсвэр | Эрүүл мэндийн яам /цаашид "ЭМЯ" гэх/ |
| | | | Иргэний эрүүл мэндийн бүртгэл (EHR) нэвтрүүлсэн эрүүл мэндийн байгууллагын хувь | 100 | | |
| 13.2 | "МУТХҮБ-2030"-ын 2.2.2, Зорилт 2, "ТЭМТББ"-ын 2.4.1.8 дахь заалт, Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний | Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах | 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин, промиль | 23.0-аас ихгүй | 0.75<br>Улсын төсөв | ЭМЯ |
| | | | 1000 амьд төрөлтөд ногдох 5 хүртэлх эндэгдлийн түвшин, промиль | 15.0-аас ихгүй | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөрийн 3.2 дахь заалт | | | | | |
| 13.3 | "МУТХҮБ-2030"-ын 2.2.2, Зорилт 3, "ТЭМТББ"-ын 2.4.2.12 дахь заалт, "ХБӨТҮХ"-ийн 3.2 дахь заалт | Зонхилон тохиолдох халдварт бус өвчний тархалт, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах | 10000 хүн амд ногдох зүрх судасны тогтолцооны шалтгаалсан нас баралт | 17.4-өөс ихгүй | 11.0 Улсын төсөв | ЭМЯ |
| | | | 10000 хүн амд ногдох хорт хавдраас шалтгаалсан нас баралт | 10.5-аас ихгүй | | |
| | | | 5-12 настай хүүхдийн шүд цоорлын тархалтын бууралтын хувь | 11.2 | | |
| 13.4 | "МУТХҮБ-2030"-ын 2.2.2, Зорилт 4, "ТЭМТББ"-ын 2.4.1.11 дэх заалт, Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр /цаашид "ХӨСХҮХ" гэх/-ийн 3.1, 3.4 дэх заалт | Халдварт өвчний тандалтын тогтолцоог бэхжүүлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх | 10000 хүн амд ногдох сүрьеэгийн тохиолдол | 14.4-өөс ихгүй | 12.0 Улсын төсөв | ЭМЯ |
| | | | Улирлын томуугийн эсрэг вакцинжуулалт хамрагдсан 6-аас дээш сартай хүн амын эзлэх хувь | 40.0 | | |
| | | | Умайн хүзүүний хорт хавдрын вакциныг нэвтрүүлсэн аймаг, нийслэлийн тоо | 5 | | |
| | | | Анагаахын чиглэлийн сургуульд шинээр элсэн орсон оюутнуудын элэгний В вирусийн эсрэг дархлаажуулалтын хувь | 95.0 | | |
| 13.5 | "МУТХҮБ-2030"-ын 2.2.2, Зорилт 1, "ТЭМТББ"-ын 2.4.4.3, 2.4.6.8 дахь заалт, "ХБӨТҮХ"-ийн 3.2 дахь заалт | Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг эмчилгээ үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлэх | Ахмад настанд олгох болон нэн шаардлагатай эмийн хөнгөлөлтийн хувь | 80.0 | 180.0 Эрүүл мэндийн даатгалын сан | ЭМЯ |
| | | | Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, протезийн нэр төрөл, хэмжээг нэмэгдүүлэх хувь | 20.0 | | |
| | | | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хувь | 70.0 | | |
| 13.6 | "МУТХҮБ-2030"-ын 2.2.2, Зорилт 1, | Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, | Шинээр ашиглалтад орох эмнэлгийн тоо | 28 | 69.5 Улсын төсөв | ЭМЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | "ТЭМТББ"-ын 2.4.2.5, 2.4.2.12 дахь заалт, "ХӨСХҮХ"-ийн 3.3 дахь заалт | сорьц тээвэрлэлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | Сорьц тээвэрлэж буй эрүүл мэндийн байгууллагын хувь | 100 | | |
| | | | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 100 | | |
| **Зорилт 14. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 14.1 | Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийн 8 дугаар бүлгийн 13 дахь заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн 3.3.1.3 дэх заалт, Ахмад настны төрөлжсөн асрамжийн шинэчлэлийн хөтөлбөр | Хүн амын бүлгүүдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх | Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар | 80.0 | - | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам /цаашид "ХНХЯ" гэх/ |
| | | | Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлэх залуучуудын хувь | 51-ээс доошгүй | - | |
| | | | Шинээр байгуулах хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн төв | 6 | 17.6 Гадаад эх үүсвэр | |
| | | | Ахмад настны төрөлжсөн асрамжийн шинэчлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар | 100 | - | |
| 14.2 | "МУТХҮБ-2030"-ын 2.2.1, Зорилт 2 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх | Шинээр бий болох ажлын байрны тоо | 10.0 мянгаас доошгүй байнгын, 15.0 мянгаас доошгүй түр ажлын байр | 35.0 ХЭДС | ХНХЯ |
| | | | Хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдах иргэдийн тоо | 60.0 мянган иргэн | | |
| 14.3 | "МУТХҮБ-2030"-ын 2.2.1, Зорилт 2 | Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 1.5 | ХНХЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | системийг боловсронгуй болгон хөгжүүлэх | | | Гадаад эх үүсвэр | |
| 14.4 | "МУТХҮБ-2030"-ын 2.2.1, Зорилт 1 | Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | Шинээр бий болох ажлын байрны тоо | 1500 | 24.0 Улсын төсөв | ХНХЯ |
| 14.5 | "МУТХҮБ-2030"-ын 2.2.1, Зорилт 2 | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний үйлчилгээг төрийн цахим мэдээлэл солилцох системтэй уялдуулан цахимжуулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 0.08 ХЭДС | ХНХЯ |
| 14.6 | "МУТХҮБ–2030"-ын 2.2.1, Зорилт 1 | Инфляцын түвшинтэй уялдуулан төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ХНХЯ |
| 14.7 | Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого /цаашид "ТТШТББ" гэх/-ын 3.2.16 дахь заалт | Инфляцын түвшинтэй уялдуулан Нийгмийн даатгалын сан болон Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ХНХЯ |
| 14.8 | "ТТШТББ"-ын 3.2 дахь заалт | Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх | Боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо | 5 | - | ХНХЯ |
| 14.9 | "МУТХҮБ-2030"-ын 2.2.1, Зорилт 1 | "Нийгмийн халамжийн мэдээллийн нэгдсэн систем"-ийг нэвтрүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ХНХЯ |
| 14.10 | "МУТХҮБ-2030"-ын 2.2.1, Зорилт 1, Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр | Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | Боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо | 1 | - | ХНХЯ |
| | | | Төрөлжүүлэн хөгжүүлэх Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тоо | 10-аас доошгүй | - | |

**ТАВ. ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГО**

**Зорилт 15. Хууль зүй, дотоод хэргийн салбарын эрх зүйн орчныг сайжруулж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах нөхцөлийг сайжруулна.**

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 15.1 | “МУТХҮБ-2030”-ын Зорилго 4, Зорилт 1 | Хууль зүй, дотоод хэргийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах | Шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн тоо | 3 | - | Хууль зүй, дотоод хэргийн яам / цаашид “ХЗДХЯ” гэх/ |
| 15.2 | “МУТХҮБ-2030”-ын Зорилго 4, Зорилт 1 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шинэтгэх, талуудад мэдээллийг түргэн шуурхай хүргэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 10.5 Улсын төсөв | ХЗДХЯ |
| 15.3 | “МУТХҮБ-2030”-ын Зорилго 4, Зорилт 1 | Цагдаагийн байгууллагын хэт богино долгионы радио холбоог үе шаттайгаар иж бүрэн шинэчлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 25.0 | 0.9 Улсын төсөв | ХЗДХЯ |
| 15.4 | “МУТХҮБ-2030”-ын Зорилго 4, Зорилт 1 | Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах, орон нутгийн иргэдийн аюулгүй байдлыг хангах барилга байгууламжийн нөхцөлийг сайжруулах | Орон нутгийн иргэдийн аюулгүй байдлыг хангах цагдаагийн тасгийн байр | 1 суманд | 1.4 Улсын төсөв | ХЗДХЯ |
| | | | Стандарт шаардлагад нийцсэн камержуулах үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | | |
| 15.5 | “МУТХҮБ-2030”-ын Зорилго 4, Зорилт 1 | Улсын болон орон нутгийн чанартай авто замын дагуу тээврийн хэрэгслийн зөрчлийг хянах дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх | Улсын чанартай авто замд камерын хяналт нэвтрүүлэх хувь | 10.0 | 3.0 Улсын төсөв | ХЗДХЯ |
| | | | Зөрчил илрүүлэлтийн өсөх хувь | 20.0 | | |
| | | | Зам тээврийн гэмт хэргийн бууралтын хувь | 10.0 | | |
| 15.6 | “МУТХҮБ-2030”-ын Зорилго 4, Зорилт 1 | Хилийн анги, салбарыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, цахилгаан хангамжийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр шинэчлэн, хилийн цэргийн төв архивын хадгаламжийн сан хөмрөгийг стандарт шаардлагад нийцүүлэх | Нийт шинэчлэгдэх автотехникийн хувь | 20.0 | 1.2 Улсын төсөв 4.8 Бусад эх үүсвэр | ХЗДХЯ |
| | | | Хамрагдах анги байгууллагын тоо | 2 | | |
| | | | Хилийн салбаруудын эрчим хүчний найдвартай эх үүсгүүрээр хангагдах хувь | 20.0 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 15.7 | "МУТХҮБ-2030"-ын Зорилго 4, Зорилт 1 | Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих "Цахим хяналт, удирдлагын төв"-ийг байгуулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 39.6 Гадаад эх үүсвэр | ХЗДХЯ |
| 15.8 | Нэг иргэн-нэг бүртгэл үндэсний хөтөлбөрийн 3.8.2 дахь заалт | Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх | "Нэг иргэн-нэг бүртгэл" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар | 60.0 | 7.5 Улсын төсөв | ХЗДХЯ |
| 15.9 | Нэг иргэн-нэг бүртгэл үндэсний хөтөлбөрийн Зорилт 1 | Улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагаа болон үйлчилгээг стандартын дагуу явуулах техникийн нөхцөлийг хангаж, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 60.0 | 4.0 Улсын төсөв | ХЗДХЯ |
| 15.10 | "МУТХҮБ-2030"-ын Зорилго 4, Зорилт 1 | "ISM" системийн өргөтгөл, сайжруулалтын хүрээнд "APIS буюу APP" системийг холбож, мэдээлэл солилцоог сайжруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 0.2 Улсын төсөв | ХЗДХЯ |
| 15.11 | "МУТХҮБ-2030"-ын Зорилго 4, Зорилт 1 | Төрийн архивын баримтуудыг цахим хэлбэрт шилжүүлэх | Цахим хэлбэрт шилжүүлэх ажлын явц, хувиар | 25.0 | - | ХЗДХЯ |
| 15.12 | "МУТХҮБ-2030"-ын Зорилго 4, Зорилт 1 | Архивын ерөнхий газрын шинэ цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 52.6 Гадаад эх үүсвэр | ХЗДХЯ |
| 15.13 | "МУТХҮБ-2030"-ын Зорилго 4, Зорилт 1 | Цагдаагийн байгууллага болон яаралтай тусламжийн дуудлага мэдээлэл хүлээн авах EIN системийн сүлжээг шинэчлэх | EIN системд холбогдох байгууллагын тоо | 54 | 0.1 Улсын төсөв | ХЗДХЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 15.14 | "МУТХҮБ-2030"-ын Зорилго 4, Зорилт 1 | Нийгмийн зорилтот бүлгийн иргэд, Эрүүгийн хэргийн хохирогч, иргэн, захиргааны хэргийн төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн холбогдогчдод үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ХЗДХЯ |
| 15.15 | "МУТХҮБ-2030"-ын Зорилго 4, Зорилт 1 | Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгааны үр дүн, мэдээлэл солилцох ажлыг идэвхжүүлэх хүрээнд цахим сан бүрдүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ХЗДХЯ |
| 15.16 | "МУТХҮБ-2030"-ын Зорилт 2.4 | Прокурорын байгууллагын ажиллах нөхцөлийг сайжруулах | Шинээр ашиглалтад оруулах барилга, байгууламжийн тоо | 5 | 17.8 Улсын төсөв | Улсын Ерөнхий прокурорын газар |
| **Зорилт 16. Үндэсний стандартын тоог нэмэгдүүлж, мэргэжлийн хяналтын салбарын орон нутаг дахь чадавхыг бэхжүүлнэ.** | | | | | | |
| 16.1 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.1-2.1.3, 2.1.5, 2.1.7 дахь заалт | Ноос, ноолуур, арьс шир, оёмол бүтээгдэхүүн, аялал жуулчлал, хүнсний салбарын үндэсний стандартыг шинээр боловсруулж мөрдүүлэх | Шинээр боловсруулж батлуулах стандартын тоо | 5 | - | Стандарт, хэмжил зүйн газар |
| 16.2 | "МУТХҮБ-2030"-ын 2.1.7, Зорилт 1 | Мэргэжлийн хяналтын байгууллагын орон нутаг дахь чадавхыг бэхжүүлэх | Шинээр ашиглалтад орох барилгын тоо | 2 | 2.6 Улсын төсөв | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар |
| **Зорилт 17. Цахим хэлбэрээр худалдаа хийх бэлтгэлийг хангаж, хилийн чанад дахь Монгол иргэдэд үзүүлэх үйлчилгээг бэхжүүлнэ.** | | | | | | |
| 17.1 | Гадаад бодлогын үзэл баримтлал /цаашид "ГБҮБ" гэх/-ын 2.14.1 дэх заалт | Монгол Улс-ОХУ-БНХАУ-ын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хөрөнгө оруулалт, зураг төслийн хамтарсан төв байгуулах ажлыг эрчимжүүлэх | Төв байгуулах ажлын явц, хувиар | 50.0 | 0.3 Улсын төсөв | Гадаад харилцааны яам /цаашид "ГХЯ" гэх/ |
| 17.2 | "ГБҮБ"-ын 3.21.6 дахь заалт, Монгол экспорт хөтөлбөрийн 4.3.1 дэх заалт | Худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагааг идэвхжүүлэх хүрээнд цахим хэлбэрээр худалдаа хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх | Шинээр нэгдэн орох хэлэлцээр | 1 | 0.3 Улсын төсөв | ГХЯ |
| | | | Хэрэгжилтийг хангах хэлэлцээр | 1 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 17.3 | “ГБҮБ”-ын 2.10, 6.26, 6.27.2 дахь заалт | Хилийн чанад дахь монгол иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангах замаар консулын албыг бэхжүүлэх | Цахим хэлбэрт шилжих үйлчилгээний нэр төрөл | 5 | - | ГХЯ |
| | | | Шинээр нээж ажиллуулах консулын газар | 1 | | |
| 17.4 | “ГБҮБ”-ын 3.21.1 дэх заалт, Монгол экспорт хөтөлбөрийн 2.2.3, 3.1.2 дахь заалт | Монгол экспорт хөтөлбөрийн 2 дахь үе шатны хэрэгжилтийг хангах | Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар | 70.0 | - | ГХЯ |
| 17.5 | “ГБҮБ”-ын 6.27.7 дахь заалт | Хилийн чанадад зорчиж буй иргэдийн хариуцлагыг дээшлүүлэх зорилготой “Хариуцлагатай аялцгаая” аяны хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ГХЯ |
| 17.6 | “ГБҮБ”-ын 7.29.1-7.29.3 дахь заалт, Монгол экспорт хөтөлбөрийн 4.2.8 дахь заалт | Монгол Улсыг гадаадад сурталчлах “Монгол Үндэстний үнэлэмж” хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар | 30.0 | 0.3<br>Улсын төсөв | ГХЯ |
| **Зорилт 18. Батлан хамгаалах салбарын сургалтын орчныг бэхжүүлж, дээвэр төслийг хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 18.1 | “МУТХҮБ-2030”-ын 2.4 дэх заалт, “ТЦБХС-2030”-ын 4.1.2 дахь заалт | Зэвсэгт хүчний хээрийн хөдөлгөөнт холбооны зангилгааг шинэчлэх, хээрийн удирдлагын байруудад сансрын холбооны бага оврын станцуудыг суурилуулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 1.9<br>ЗХХС | Батлан хамгаалах яам /цаашид “БХЯ” гэх/ |
| 18.2 | “МУТХҮБ-2030”-ын 2.4 дэх заалт, “ТЦБХС-2030”-ын 4.1.2 дахь заалт | Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудыг шилэн кабелийн нэгдсэн сүлжээнд холбох | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 2.2<br>ЗХХС | БХЯ |
| 18.3 | “МУТХҮБ-2030”-ын 2.4 дэх заалт, “ТЦБХС-2030”-ын 4.1.6 дахь заалт | “Дээвэр” төслийг хэрэгжүүлж, зэвсэгт хүчний зарим анги, салбаруудын барилга, байгууламжийн дээврийг засварлах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 1.2<br>ЗХХС | БХЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 18.4 | "МУТХҮБ-2030"-ын 2.4 дэх заалт, "ТЦБХС-2030"-ын 4.1.1 дэх заалт | Батлан хамгаалах салбарын сургалтын орчныг бэхжүүлэх | Шинээр ашиглалтад орох барилгын тоо | 1 | 1.6<br>Улсын төсөв | БХЯ |
| 18.5 | "МУТХҮБ-2030"-ын 2.4 дэх заалт, "ТЦБХС-2030"-ын 4.1.2 дахь заалт | Зэвсэгт хүчний анги салбаруудыг харилцаа холбооны техник хэрэгслээр хангах | Техник, тоног төхөөрөмжөөр хангах ажлын явц, хувиар | 100 | 1.0<br>Улсын төсөв | БХЯ, ЗХЖШ |
| 18.6 | "МУТХҮБ-2030"-ын 2.4 дэх заалт, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.2.1, 3.1.4.3 дахь заалт, Батлан хамгаалах бодлогын үндэс 5.3 дахь заалт | Хүүхэд, залуучуудад цэрэг эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, эх түүх, эх хэл, өв соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлэх | Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар | 40.0 | - | БХЯ, ЗХЖШ |
| 18.7 | Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.2.2 дахь заалт, Батлан хамгаалах бодлогын үндэс 2.3 дахь заалт | Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог төлөвшүүлэх, зэвсэгт хүчний төрлийн цэргийн загвараар хөгжүүлэх замаар батлах хамгаалах чадварыг нэмэгдүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | БХЯ |

-----oOo-----